



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сеулийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2014.03.31 № 01/2439

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Ш.ТҮВДЭНДОРЖ ТАНАА

Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д заасны дагуу албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын 2013 оны мэдүүлгийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан, мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайлангийн нэгдсэн дүнгийн тухай мэдээллийг хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



Н.ГАНБОЛД

001281

**НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ 2013 ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН
МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ШИНЭЧЛЭН
БҮРТГЭСЭН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2014.03.27

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 112 байгууллагаас мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2013 оны тайлан мэдээг авч нэгтгэлээ.

2013 оны бүрдүүлэлтээр төрийн болон нутгийн захиргааны төв 110 байгууллага байсан бол 2014 онд “Монголын мянганы сорилтын сан” хасагдаж, Газрын Шинэтгэлийн Үндэсний Хорооны ажлын алба, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Төрийн тусгай хамгаалалтын газар гэсэн 3 байгууллага нэмэгдсэн.

Мөн 2013 оны бүрдүүлэлтээс энэ жилийн хувьд мэдүүлэг гаргагчдын тоо 4442-аар нэмэгдсэн нь өнгөрсөн онд хийгдсэн төрийн байгууллагуудын бүтэц, орон тооны өөрчлөлт, 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд төрийн үйлчилгээний байгууллага /боловсрол, эрүүл мэнд/-ын зарим удирдах албан тушаалтнууд нэмэгдэж орсон, хуучин Хадгаламж банкнаас Төрийн банкинд шилжиж ирсэн удирдах албан тушаалтнууд болон аймаг, нийслэл дүүргийн Засаг даргын тамгын газрын дэргэд худалдан авах ажиллагаа, дотоод аудитын алба нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлж байна.

Авлигатай тэмцэх газарт 2013 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлбэл зохих 267 албан тушаалтан байгаагаас албан тушаал дээрээ ажиллаж байгаа 266 мэдүүлэг гаргагч 100% мэдүүлгээ гаргаж бүртгүүлсэн. Нэг албан тушаалтан хүндэтгэн үзэх шалтгаантай буюу удаан хугацаагаар өвчтэй байна. 2014 онд шинээр 7 албан тушаалтан томилогдсон бол Авлигын эсрэг хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр 11 мэдүүлэг гаргагч шинээр бүртгэгдэж мэдүүлгээ тус газарт бүртгүүлсэн.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв 112 байгууллагын мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2014 оны тайлан мэдээг нэгтгэсэн. Улсын хэмжээнд **51584** мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс **51579** мэдүүлэг гаргагч буюу **99,99** хувь нь мэдүүлгээ бүртгүүлсэн. Үүнээс **51573** мэдүүлэг гаргагч буюу **99,98** хувь нь хуульд заасан хугацаанд бүртгүүлсэн, 6 мэдүүлэг гаргагч буюу 0,01 хувь нь хугацаа хожимдуулж мэдүүлсэн бол 5 мэдүүлэг гаргагч буюу 0,01 хувь нь мэдүүлгээ огт гаргаж өгөөгүй байна.

Мэдүүлгээ гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулсан 11 мэдүүлэг гаргагчаас төрийн тусгай албан хаагч 2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч 1, төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан 4, төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн 3, төрийн үйлчилгээний байгууллагын удирдах 1 албан тушаалтан байна.

Мэдүүлгийн бүрдүүлэлтээр мэдүүлгээ гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулсан 11 мэдүүлэг гаргагчид Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах, мэдүүлгийг нөхөн гаргуулан авах, хууль тогтоомжийн

хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичгийг хүргүүлсэн. /Мэдүүлгийн бүрдүүлэлтийн сүүлийн 5 жилийн тоо, мэдээг хавсралт 1-ээр харуулав./

Хавсралт 1

Үзүүлэлт		2009 оны ХОМ	2010 оны ХОМ	2011 оны ХОМ	2011 оны ХАСХОМ	2012 оны ХАСХОМ	2013 оны ХАСХОМ
Бүртгүүлбэл зохих мэдүүлэг гаргагчийн тоо		54604	56832	58251	45858	47142	51584
Бүртгүүлсэн нийт мэдүүлэг гаргагчийн тоо		54468	56763	58187	45762	47127	51573
Үүнээс	Хугацаандаа мэдүүлсэн	54453	56714	58162	45755	47105	51573
	Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	15	49	25	7	22	6
Огт бүртгүүлээгүй мэдүүлэг гаргагчийн тоо		136	69	64	96	15	5
Үүнээс	ИТХ-ын төлөөлөгч	98	61	50	83	16	1
	Бусад	38	8	14	20	21	10
Бүрдүүлэлтийн хувь		99.75	99.87	99.89	99.79	99.97	99.99

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд төрийн тусгай 4 байгууллагын 4737, төрийн өмчит хуулийн этгээд /гадаад/-ийн 28, нийт 4765 мэдүүлэг гаргагч бүртгэгдээгүй.

2013 оны мэдүүлгээ шинэчлэн гаргасан мэдүүлэг гаргагчдын ангилал, зэрэглэлийн судалгааг нэгтгэн гаргасан. Үүнд:

Үзүүлэлт	ТЗ	ТТ	ТӨАТ	УТ	ТӨХЭ	ТҮ	ТББ	Бусад	Нийт
Тоо	18681	16404	338	7702	2012	4711	24	1707	51579
Хувь	36,22%	31,8%	0,66%	14,93%	3,9%	9,13%	0,05%	3,31%	100%

Нийт мэдүүлэг гаргагчын 21828 буюу 42,32 хувь нь Улаанбаатар хотод байгаа бол 29751 буюу 57,68 хувь нь орон нутагт байна.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн нэгдсэн тайлангаар хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлтийн талаар мэдүүлсэн 2293, ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл гаргасан 13135, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргасан 167, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргасан 10490, давхар ажил эрхлэлтийн талаар танилцуулсан 152, ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдээлсэн 14 албан тушаалтан байна.

Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын судалгааг 2014 оны 03 дугаар 03-ны байдлаар нэгтгэн гаргасан ба төрийн захиргааны болон нутгийн захиргааны төв 112 байгууллагад 120, түүний салбар нэгжийн байгууллагуудад 1508, нийт 1628 мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан бүртгэгдсэн.

Нийт эрх бүхий албан тушаалтнуудын 25 хувь нь нийслэлд, 75 хувь нь орон нутагт байна. Өнгөрсөн жилийн судалгаанаас эрх бүхий албан тушаалтнуудын тоо нэмэгдсэн ба энэ нь аймаг, дүүргүүдэд худалдан авах ажиллагааны алба, 9 дүүрэгт боловсролын хэлтэс, 21 аймагт төрийн банкны салбарт болон босоо тогтолцоотой болсон Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөрийн яамны харьяа салбар, нэгжүүдэд эрх бүхий албан тушаалтан шинээр томилогдсоноос голчлон шалтгаалсан байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР